

**“ГАСУУНСУХАЙТ-ГАНЦМОД БООМТЫН ХИЛ ДАМНАСАН ТӨМӨР ЗАМ,  
НҮҮРСНИЙ ХУДАЛДАА, ТАВАНТОЛГОЙН НҮҮРСНИЙ УУРХАЙН ХҮЧИН ЧАДЛЫГ  
НЭМЭГДҮҮЛЭХ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН  
ГАЗАР БОЛОН БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР  
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ  
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025 он

## ГАРЧИГ

НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

## **НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр баталсан бөгөөд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийн нэгт Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр болсон.

УИХ-ын 2024 оны 58 дугаар тогтоолын 1 дэх заалтын 7/“Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтад “Нэг зураг төсөлтэй, нэг гүйцэтгэгчтэй, бүтээн байгуулалтыг зэрэг эхлүүлж, зэрэг дуусгах” зарчим баримтлах”, 8/“Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам барих, түүнийг холбох бүтээн байгуулалтын төслийн ажлыг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэн хамтран ажиллана.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолоор 1955 оны Монгол-Хятадын хилийн төмөр замын Хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор холбогдох арга хэмжээ авахыг даалгасан. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоолоор Монгол, Хятадын “Гашуунсухайт-Ганцмод” хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Тавантолгой төмөр зам” ХХК-д 5 жилийн хугацаатай олгож, төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг холбогдох стандартад нийцүүлэн батлагдсан зураг төслийн дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хил доторх “Ганцмод” боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц эзэмшигч төрийн өмчит компаниар гүйцэтгүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрсөн.

Мөн 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр гарын үсэг зурсан “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Хил дамнасан төмөр замын гүүрний бүтээн байгуулалтыг гүйцэтгэх байгууллага нь: Монголын талаас “Тавантолгой төмөр зам” ХХК, Хятадын талаас “Чайна энерги хөрөнгө оруулалтын групп” ХХК байна гэж заасныг тус тус үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцсон.

Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд БНХАУ-ын “Чайна энерги Ганцмодны төмөр замын хөрөнгө оруулалт” ХК-тай тус төмөр замын төслийг хамтран барьж, ашиглалтад оруулах зорилгоор “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хамтран барих тухай хэлэлцээр”-ийг, улмаар БНХАУ-ын талын сонгон шалгаруулсан аж ахуйн нэгжээр төмөр зам, түүнийг холбох барилга байгууламжийг гүйцэтгүүлэхээр Барилгын ажил гүйцэтгэх гэрээг тус тус байгуулж, төмөр замын төслийг хэрэгжүүлнэ.

## **ХОЁР. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан улс орны эдийн засагт чухал нөлөөтэй Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр

замын төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой хуулийн этгээдэд үүсэх зардлыг тус тайлангийн нэг дэх хэсэгт заасан үндэслэлийн хүрээнд тодорхойлон гаргасан.

“Тавантолгой төмөр зам” ХХК нь ТТЗ/202302079 дугаартай “Хил холболтын төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл болон иж бүрэн зураг төслийн Зөвлөх үйлчилгээний гэрээ”-г “Хятадын төмөр замын зураг төслийн корпорац” ХХК-тай 2023 оны 05 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан.

Зам, тээврийн яамны Шинжлэх, ухаан технологийн дэд зөвлөл болон зөвлөлөөр 2023 оны 08 дугаар сарын 18, 21-ний өдрүүдэд тус тус хэлэлцүүлж нийт 77 зөвлөмж авч засан, сайжруулан 2023 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Шинжлэх, ухаан технологийн дэд зөвлөлөөр орж дэмжигдсэн. ЗТХЯ-ны 2023 оны 9 сарын 29-ний өдрийн 08/4591 тоот дугаартай албан бичгээр ТЭЗҮ-ийг нарийвчилсан зураг төсөл магадлуулах хүрээнд магадлуулах чиглэл ирүүлсэн. Энэ хүрээнд “Техник эдийн засгийн үндэслэл” 2024 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр магадлагдсан.

Техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаагаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг бүтээн байгуулалтын барилга угсралтын ажлыг 2 жилийн хугацаанд гүйцэтгэхээр тусгасан байна.

Хуулийн этгээдэд үүсэх зардал нь Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн бүтээн байгуулалтын үед шаардлагатай санхүүжилт буюу 908.5 тэрбум төгрөг (НӨАТ-тай дүн) болно.

Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоолын 4-т “Бүтээн байгуулалтын ажлын төсвийн магадлагдсан дүнд багтаан гүйцэтгэгч, захиалагч нартай санхүүжилтийн 3 талт гэрээ байгуулан зохих журмын дагуу санхүүжүүлэх арга хэмжээ авахыг “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ТУЗ-д даалгасугай” гэж заасны дагуу тус төслийн нийт өртгийг урьдчилсан байдлаар 908.5 тэрбум.төгрөгөөр тооцоолоод байна.

*Хүснэгт 1. Гашуунсухайт\*Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн төсөв /урьдчилсан дүнгээр/*

Д/д	Утга	Төсвийн дүн /сая төг/
1	Төмөр замын доод бүтэц	102,533.2
2	Төмөр замын дээд бүтэц	81,656.4
3	Гүүр, хоолой	387,659.6
4	Авто зам	19,818.1
5	Эрчим хүч	7,680.3
6	Дохиолол холбоо	55,012.0
7	Барилга	115,183.3
8	Гааль хилийн хяналт, зүтгүүр, машин механизм, тоног төхөөрөмж	94,860.1
9	Түлшний сав холболтын шугам сүлжээ /одоогийн шатахуун шахах хоолойноос шинээр барим шатахуун шахах гүүрэн байгууламжтай холбох ажил/	50.0
10	Хил, гаалийн шалган нэвтрүүлэн тоног төхөөрөмжийн шугам хоолой/цайрдсан ган хоолойн сувагчлал хийх ажил/	437.3

11	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	94.1
12	Нэмэгдэл зардлууд /ЗХЗ, Зураг төсөл, магадалшгүй ажил, норм нормативын сан/	43,544.1
	<b>Дүн</b>	<b>908,528.5</b>

Иймд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлын төсвийн дүнг удирдлага болгон “хуулийн этгээдэд шаардагдах зардал”-ыг 908.5 тэрбум төгрөгөөр тодорхойлж байна.

### **ГУРАВ. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь иргэнд тодорхой үүрэг гүйцэтгэхийг даалгасан эсэхийг судалж үзсэн.

Тухайн хуулийн төслөөр иргэнд үүсэх зардлыг тооцоолох эхний алхам буюу иргэнд үүсгэсэн үүргийг тогтоох үед хэлэлцээрийн төсөл нь иргэнд үүрэг үүсгээгүй, иргэдэд хамааралтай зохицуулалт байхгүй тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй юм.

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь иргэнд зардал үүсгэхгүй гэж үзлээ.

### **ДӨРӨВ. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТООЦОО**

Хуулийн төсөл нь “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь төрийн байгууллагад ямар үүргийг шинээр бий болгож байгааг тодорхойлж уг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай баримт бичгийн агуулгыг тодорхойлсны үндсэн дээр зардлын тооцоог хийх болно.

Үүний тулд соёрхон батлагдах “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т төрийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн заалт байгаа эсэхийг судалж үзсэн.

Тухайн хуулийн төслөөр улсын төсөвт үүсэх зардлыг тооцоолох эхний алхам буюу төрийн байгууллагад үүсгэсэн үүргийг тогтоох үед хуулийн төсөл нь төрийн байгууллагад үүрэг үүсгээгүй байх тул цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй юм.

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл нь улсын төсөвт зардал үүсгэхгүй гэж үзлээ.

Харин төсөл хэрэгжүүлсэнтэй холбогдуулан улсын төсөвт тодорхой орлогуудыг төвлөрүүлэх боломжтой. Төслийн барилга угсралтын ажлын үргэлжлэх хугацааг 2 жил байхаар техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаагаар тогтоосон бөгөөд тус хугацаанд улсын төсөвт нэмэгдсэн өртгийн албан татвар зардалд 70.4 тэрбум төгрөгийг төлөх урьдчилсан тооцоотой байна.

### ТАВ.ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН СУДАЛГААН ДАХЬ САНХҮҮ, ҮР, АШГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

*Хүснэгт 2.Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаан дахь санхүү, үр, ашгийн үзүүлэлтүүд*

Санхүүгийн шинжилгээ /Cost Benefit Analysis/		Төсөл	
		Гашуунсухайт-Ганцмод	Тавантолгой-Ганцмод
Үндсэн өгөгдөл /Key Assumptions/:			
Дискаунт хүү /Discount Rate/		8.00%	
Тооцооллын жил /Appraisal period (years)/		30 жил /years/	
Санхүүгийн шинжилгээний үр дүнгийн тойм / Summary of the Results of the Analysis			
Хөрөнгө оруулалт /Capital Costs/	сая.төг	868,589₮	4,269,189₮
Үр өгөөж /Internal rate of return/ IRR	%	4.21%	25.11%
Төслийн ашиг /Net Present Value/ NPV	сая.төг	-384,217₮	26,294,433₮
Эргэн төлөгдөх хугацаа	жил	21.33жил	5.56 жил

Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацааг зөвхөн тухайн хэсэглэл буюу Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн үзүүлэлтээр тооцоход 21.3 жил гэж тооцсон ба тус төсөл нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн үргэлжлэл болж, Тавантолгойн бүлэг ордоос экспортын нүүрсийг хил дамнуулан тээвэрлэх үүрэг бүхий цогцолбор төслийн нэг хэсэг учраас үр ашгийн тооцоог цогцолбор төслийн хүрээнд авч үзэн 5.6 жилд хөрөнгө оруулалтаа нөхөхөөр тооцоолсон байна.

*Хүснэгт 3.Төслийн санхүү, эдийн засгийн үр өгөөж*

Д/д	Үр өгөөж
-----	----------

Үндэслэл 1	<p>Тус төмөр зам барьж байгуулагдан ашиглалтад орсноор дараах хоорондоо уялдаа бүхий төслүүдийн үйл ажиллагаанд эергээр нөлөөлнө. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. “Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам” төсөл</li> <li>2. “Тавантолгой нүүрс ачих логистикийн төв” төсөл</li> <li>3. “Тавантолгойн нүүрс баяжуулах үйлдвэр” төсөл</li> </ol>
Үндэслэл 2	<p>Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн бүтээн байгуулалтын ажлыг хийснээр Монгол улсын төмөр замын хөгжлийн үндсэн чиглэл, олон улсын төмөр замын эрх зүйн болон гадаад харилцааны гэрээ хэлэлцээр, тэдгээрийн туршлагад үндэслэсэн эдийн засгийн, бизнесийн болоод хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны хувьд өндөр ач холбогдолтой жишиг болж, дараа дараагийн экспортод чухал нөлөөтэй хил холболтын төмөр замын төслүүдэд эерэг нөлөөг үзүүлнэ.</p>
Үндэслэл 3	<p>Төсөл хэрэгжсэнээр уул, уурхай, дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон төслүүд эрчимжин, эдийн засгийн эргэлтэд орох боломж бүрдэх бөгөөд бүтээмж, өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалт болон ашигт ажиллагаа өсөж, улс орон, бүс нутгийн нийгэм, эдийн засагт эерэг нөлөөг үзүүлнэ.</p> <p>Түүнчлэн Монгол улсын уул уурхайн түүхий экспортын чухал зангилаа болсон Гашуунсухайт, Шивээхүрэн, Хөөт, Ханги, Зүүнбаян зэрэг төмөр замыг дагасан тээвэр, логистикийн сүлжээ үүсэн бий болоход эерэг нөлөөтэй.</p>
Үндэслэл 4	<p>Тус төмөр зам барьж байгуулагдан ашиглалтад орсноор бусад төслүүдэд нөлөөлөх замаар эдийн засагт дараах эерэг үр дүнг бий болгоно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гашуунсухайт-Ганцмод боомтод түшиглэсэн цогц төслүүд эдийн засгийн өсөлтийг жилд 1.8-3.2%-иар өсгөж, дунжаар 4.8-5.4 тэрбум ам.долларын нэмүү өртгийг үйлдвэрлэж, 5000 орчим шинэ ажлын байх ба түүнийг дагасан 1800-3200 шууд бус хөдөлмөр эрхлэлтийг үүсгэнэ;</li> <li>- Нүүрсний экспорт 2 дахин өсөх боломж бүрдэж, нүүрс тээвэрлэлтийн өртөг 2-2.5 дахин буурна;</li> <li>- Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулна;</li> </ul> <p>Тус төмөр зам барьж байгуулагдан ашиглалтад орсноор дараах ач холбогдолтой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хоёр улсын тэргүүн нарын 2014 онд баталсан “Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал” хэрэгжих нөхцөл бүрдэнэ. Тус тунхаглал хэрэгжсэнээр Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, олон улс бүс нутгийн хамтын ажиллагаа, Эрдэс баялаг, Аж үйлдвэр, Дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжихээс гадна хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх стратегийн ач холбогдолтой;</li> <li>- Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам нь өргөн царигаар жилд 30 сая тонн, нарийн царигаар 10 сая тонн ачаа тээвэрлэх хүчин чадалтай бөгөөд уг төсөл хэрэгжсэнээр 2030 оноос нүүрсний экспорт жил бүр 20 сая тонноор нэмэгдэж, эдийн засгийн өсөлт жил бүр 0.8 нэгж хувиар нэмэгдэх, ядуурлын түвшин буурч, нэг хүнд ногдох ДНБ-ийг 10000\$-т хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6%-аас</li> </ul>

	дээш түвшинд хадгалах, инфляцыг 5%-д барих зэрэг эдийн засгийн томоохон ач холбогдолтой болно.
Үндэслэл 5	Олон улсын жишгийн дагуу уул уурхайн бүтээгдэхүүнд нэмүү өртөг шингээн экспортлох зорилго хангагдаж, нүүрсний чанар бус худалдан авагчдад хүргэх хугацаа, үнэ, үйлчилгээгээр өрсөлдөх боломж үүснэ.
Үндэслэл 6	Нийгмийн хөгжлийн хувьд идэвхтэй дэд бүтэц, уул уурхай, тээвэр, логистик, агуулахын үйлчилгээг даган төвлөрлийг орон нутаг руу чиглүүлэх боломж бүрдэнэ.

--oOo--